



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/214

Улаанбаатар хот

**Улсын онцгой комиссын шийдвэрийг
хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улс, хот хоорондын зорчигч тээврийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 02:00 цагаас 11 дүгээр сарын 13-ны өдрийн 23:00 цаг хүртэл зогсоосонтой холбогдуулан дараах арга хэмжээ авч, бэлэн байдлыг хангаж ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

1.1. Хот хоорондын зорчигч тээврийн зорчих тасалбар урьдчилан худалдаж авсан зорчигчдын тасалбарын үнийг шимтгэлгүйгээр буцаан олгох, эсхүл тасалбарыг дараа ашиглах боломжоор хангах, аяллын давтамж, цагийн хуваарийг урьдчилан тооцож, зорчигч тээврийн үйл ажиллагаанд зохицуулалт хийж ажиллахыг “Иргэний нисэхийн ерөнхий газар” /Л.Бямбасүрэн/, “Улаанбаатар төмөр зам” ХНН /Д.Жигжиднямаа/, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /Б.Гүрсоронзон/-т тус тус даалгасугай.

1.2. Орон нутгийн зорчигч тээврийн галт тэрэг болон хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан зохих арга хэмжээ авч ажиллахыг “Иргэний нисэхийн ерөнхий газар” /Л.Бямбасүрэн/, “Улаанбаатар төмөр зам” ХНН /Д.Жигжиднямаа/, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /Б.Гүрсоронзон/-т тус тус даалгасугай.

1.3. Олон улс, улсын чанартай авто замыг хаах хугацаанд авто зам, замын байгууламжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг зам хариуцагч компаниудад, хяналт тавьж ажиллахыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Р.Буд/-т даалгасугай.

2. Тушаалын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар олон нийтэд урьдчилан мэдээлж ажиллахыг "Иргэний нисэхийн ерөнхий газар" /Л.Бямбасүрэн/, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ /Б.Гүрсоронзон/, "Улаанбаатар төмөр зам" ХНН /Д.Жигжиднямаа/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгасугай.

САЙД  Л.ХАЛТАР

